



ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ТОГТООЛ
АРГАЧЛАЛ БАТЛАХ ТУХАЙ / Концесс олгох уралдаант шалгаруулалтын Урьдчилсан шалгаруулалтын жишиг баримт бичиг /

2010 оны 07 дугаар сарын 22-ны өдөр Улаанбаатар хот

Дугаар 342

Концессын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх заалт, Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 177 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн өмчийн хорооноос ТОГТООХ нь:

1. "Концесс олгох уралдаант шалгаруулалтын Урьдчилсан шалгаруулалтын жишиг баримт бичиг"-ийг нэгдүгээр, "Концесс олгох уралдаант шалгаруулалтын жишиг баримт бичиг"-ийг хоёрдугаар, "Уралдаант шалгаруулалтын санал үнэлэх журам"-ыг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.
2. Концесс олгохтой холбогдсон үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэхдээ "Концесс олгох уралдаант шалгаруулалтын Урьдчилсан шалгаруулалтын жишиг баримт бичиг", "Концесс олгох уралдаант шалгаруулалтын жишиг баримт бичиг", "Уралдаант шалгаруулалтын санал үнэлэх журам"-ыг мөрдөж ажиллахыг Төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын газар /Б.Заяабал/-т даалгасугай.
3. Орон нутгийн өмчийн концессын зүйлийн хувьд Концессын эрх олгохтой холбогдсон үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэхдээ "Концесс олгох уралдаант

шалгаруулалтын Урьдчилсан
шалгаруулалтын жишиг баримт бичиг",
"Концесс олгох уралдаант шалгаруулалтын
жишиг баримт бичиг", "Уралдаант
шалгаруулалтын санал үнэлэх журам"-ыг
мөрдөж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг
дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА Д.СУГАР

ГАЗРЫН ДАРГА Л.ГАНБАТ

Улсын бүртгэлд 2011 оны 05 дугаар сарын
16-ны өдрийн 3244 дүгээрт бүртгэсэн.